



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолтыг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, тус газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын бүтэц, орон тоо батлах тухай” А/04 дүгээр тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 50, 51 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Тус газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын нэрс шинэчлэн батлагдсантай холбогдуулан, Төрийн албаны зөвлөлөөс хянаж, батлах зөвшөөрөл олгосон доор дурдсан “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт”-ыг хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

1/Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр;

2/Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар;

3/Цахим хөгжлийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар;

4/Сансрын холбооны хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр;

5/Шуудан, радио телевизийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар;

6/Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар;

7/Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар;

100360

8/Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар;

9/ Төрийн захиргааны удирдлагын газрын Төлөвлөгөө, тайлан, өргөдөл, гомдлын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр;

10/ Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар;

11/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр;

12/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар;

13/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Тоон контент хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар;

14/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Харилцаа холбооны сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр;

15/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Өргөн нэвтрүүлгийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар;

16/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар;

17/ Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа шинжилгээ, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар;

18/Цахим хөгжлийн газрын Цахим засаглал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар;

19/Цахим хөгжлийн газрын Салбар хоорондын зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр;

20/Цахим хөгжлийн газрын Нийтийн мэдээллийн дэд бүтэц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар;

21/Цахим хөгжлийн газрын Харилцаа холбооны дэд бүтэц хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр;

22/Цахим хөгжлийн газрын Тоон бичиг үсгийн боловсрол хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар;

23/Цахим хөгжлийн газрын Инноваци, гарааны бизнес хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар;

24/Цахим хөгжлийн газрын Салбар хоорондын зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 24 дүгээр;

25/Цахим хөгжлийн газрын Цахим засаглал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 25 дугаар;

26/Цахим хөгжлийн газрын Нийтийн мэдээллийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 26 дугаар;

27/Цахим хөгжлийн газрын Сансрын холбооны хэлтсийн Радио давтамжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 27 дугаар;

28/Цахим хөгжлийн газрын Сансрын холбооны хэлтсийн Сансрын холбооны технологи, хиймэл дагуулын координацын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 28 дугаар;

29/Цахим хөгжлийн газрын Шуудан, радио телевизийн хэлтсийн Шуудан, ложистикийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 29 дүгээр;

30/Цахим хөгжлийн газрын Шуудан, радио телевизийн хэлтсийн Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 30 дугаар;

31/Цахим хөгжлийн газрын Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 31 дүгээр;

32/Цахим хөгжлийн газрын Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн Мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 32 дугаар;

33/Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 33 дугаар;

34/Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 34 дүгээр.

Хоёр. Шинэчлэн батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.